

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас:70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Ахлах аудитор: Х.Манаргүл
Утас: 95429524
Цахимхаяг:

Хаяг: Баян-Өлгий аймгийн
Аудитынгазар
Байршил: Аймгийн ЗДТГ-
ын байр, 1-р давхар
Цахим хуудас:
www.audit.mn
2018 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 18-наас 1 дүгээр сарын 30-ны хооронд хийхээр төлөвлөн, Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хүнс, хөдөө аж ахуйн газар 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа аймаг дах Төрийн аудитын газарт 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 01/17 тоот албан бичгээр ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 31-нээс 2 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 09-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэнэ.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Монгол улсын Төсвийн тухай тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай

хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Мал амьтаны эрүүл мэндийн тухай хууль, органик хүнсний тухай, тариалангийн тухай, хүнсний тухай, үйлдвэрлэлийг дэмжих тухай болон бусад холбогдох хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Малын генетик нөөцийн тухай хуулийн 1-р зүйлд “Мал болон ашиг шимийг нь ашигладаг тэжээвэр амьтны генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон ба бусад холбогдох хуулиудыг мөрдөж ажилласан байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Бусад төсвийн байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны төсвийг ХХААХҮСайдын төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 5 чиглэлээр 9 эрсдэлтэй асуудалд 31 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад аймгийн ХХААГазраас 2017 онд боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэдэг байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хүнс, хөдөө аж ахуйн газрын санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Аколоус” програм хангамж ашиглажээ.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хүнс, хөдөө аж ахуйн газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу ХХААСайдын төсвийн багцаас аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан .

Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2017 онд 377,1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.Төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 373,1 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлж, 4,0 сая төгрөгийг өөрийн орлогоос бүрдүүлэн зарцуулахаар тусгажээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 373,1 сая төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоос 4,7 сая төгрөг оруулж, 365,0 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл

ажиллагаа явуулж, батлагдсан төсвөөс 12,1 сая төгрөгийг хэмнэж, улсын төсөвт төвлөрүүлсэн

Өөрийн орлогоос 4,0 сая төгрөг оруулахаас 4,7 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 0,7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн. Үүнээс 3,8 сая төгрөгийг ариун цэврийн хураамжийн төлбөрөөс, 0,8 сая төгрөгийг ариутгал халдваргүйжүүлэлтийн төлбөрөөс, бусад орлогоос 0,1 сая төгрөг оруулсан байна.

Нийт төсвийн 61,3 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 8,8 хувийг тогтмол зардал, 3,9 хувийг хангамж бараа материалын зардал, 1,3 хувийг норматив зардал, 1,2 хувийг томилолтын зардал, 4,6 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 16,2 хувийг урсгал шилжүүлэг, 2,7 хувийг эд хогшил худалдаж авах зардал эзэлж байна.

Түлш халаалтын зардлыг 12,2 сая төгрөгөөр хэмнэж, бусад зардлуудыг төсөвтөө багтаан зарцуулсан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 01/1497 дугаар албан бичгээр Хүнс хөдөө аж ахуйн газрын бүтэц орон тоог газрын дарга 1, нийтлэг үйлчилгээний ажилтан 7, үйлдвэрлэл худалдаа үйлчилээний алба 4, мал аж ахуйн алба 4, мал эмнэлгийн алба 8 буюу нийт орон тооны хязгаарыг 24-өөр баталсан байна. Гүйцэтгэлээр 24 орон тоо ажиллуулсан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 355,3 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Улсын мал эмнэлэгийн ариун цэврийн төв лабораториос шүлхий тандалт шинжилгээний зардалд 2,2 сая төгрөг, ХХААЯамнаас царцаатай тэмцэх зардалд 120,3 сая төгрөг, аймгийн Засаг даргын нөөц сангаас халдварт шинжилгээний зардалд 12,3 сая төгрөг, Мал эмнэлэг үржлийн газраас бруцеллэз өвчний вакцинуулалтын үйлчилгээний хөлс 98,5 сая төгрөг, бог малын мялзан өвчний вакцинжуулалтын үйлчилгээний хөлст 106,1 сая төгрөг, Онцгой байдлын газраас гамшгаас сэргийлэх иж бүрэн сургуулийн дайчилгааны зардалд 0,8 сая төгрөг, Мал эмнэлэг үржлийн газраас баруун бүсийн зөвлөлгөөний зардалд 0,9 сая төгрөг, Алтай шар говь ХХК наас барилгын их засврын хяналтын зардалд 0,5 сая төгрөг, авлагаас 0,6 сая төгрөг, бусад орлогоос 0,5 сая төгрөг оруулж зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл

Хүнс, хөдөө аж ахуйн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад эрсдэлтэй асуудал тогтоогдоогүй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны батлагдсан төсвийг shilendans.gov.mn вэб сайтад байршуулсан байна.Төсвийн талаарх мэдээллийг байгууллагын самбарт байршуулжээ.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөгөөр 2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар тус байгууллага шилэн дансны тухай хуулийн 4.1.3, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.4.5-т заасан заалтуудыг зөрчсөн 311,0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч биелэлтийг 2017.12.07 №01/473 тоот албан тоотоор авч хангуулсан.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-SHSHGA файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 31 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний орлого, санхүүжилт, нэмэлт санхүүжилт, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин, НДШимтгэл, ХХОАТ, түлш халаалт, тээвэр шатахуун, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг алдаа, зөрчил илрээгүй.Материаллаг бус дараах асуудал илэрсэн. Үүнд:

1.Тайлант онд тэтгэвэрт гарсан 4 хүний оронд 4 хүнийг ажилд авч батлагдсан цалингийн сандаа багтаан ажиллуулсан байна. Үүнээс 3 хүнийг 2017

оны 4 дүгээр сараас хойш ажилд авсан ба энэ нь УИХ-ын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолын 6 дах заалттай зөрчилдөж байна.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Байхгүй.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах дансдын тооцооллыг гүйцэд мөшгин шалгах боломжгүй байсан. Үүнд:

1. Малын үзлэг ангилалт, таналт шинжилгээ, бруцеллөз үйлчилгээний хөлс, царцаа, гамшгаас урьдчилан сэргийлэх, халаалт, эмийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, шатахуун зэрэг зардлуудын зарцуулалтыг гүйцэд шалгах боломжгүй учраас гүйцэтгэлийн шалгалтаар үзэх шаардлагатай.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хүнс, хөдөө аж ахуйн газрын санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын санхүүгийн тайланд зөвлөмж өгөгдөөгүй байна

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас, менежментийн захидал ... хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН
Огноо: 2018.02.12

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК
Огноо: 2018.02.12

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Х.МАНАРГҮЛ
Огноо: 2018.02.12